

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
7 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Цагаатгалын хуулинд хамрагдсан 23 иргэнээс 7-р сарын 20-ны өдрийн байдлаар 3 иргэний 120 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гарч санхүүжилт ирээгүй хүлээгдэж байна. Эхний хагас жилийн байдлаар 241 сая төгрөгийг олгох шүүхийн шийдвэр гарсны дагуу, тухайн иргэний дансанд мөнгийг шилжүүлж олголоо.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2020 оны эхний хагас жилийн тайланг холбогдох журмын дагуу боловсруулан Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд цахимаар болон албан бичгээр хүргүүлэв.

Экологийн цагдаагийн алба үүссэнтэй холбогдуулан аймгийн Цагдаагийн газрын экологийн цагдаагийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж албан хэрэгцээнд ашиглах автомашин нийлүүлсэн.

Аялал жуулчлал ихэссэнтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй төв магистрал авто замын ослын аюултай хэсгүүдэд анхааруулах мэдээллийн 10 самбар байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 278, 2020 оны 254 дүгээр захирамжуудаар баталсан журмуудын дагуу агентлаг, сумын ЗДТГ-ын 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмж хүргүүллээ.

Хүннү гүрний 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадам, аймаг байгуулагдсаны 97 жилийн ойн баяр наадмыг 7-р сарын 11,12-ны өдрүүдэд хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулсан бөгөөд аймгийн баяр наадамд 8 насны 321 хурдан морь уралдаж, улс, аймгийн алдар цолтой 128 хүчит бөх барилдсанаас Цэнхэр сумын харьяат, “Бөхбилэгт” дэвжээний бөх, сумын заан Х.Очирхуяг түрүүлж “Аймгийн арслан”, Хайрхан сумын харьяат, “Бөхбилэгт” дэвжээ, “Соёмбо” спорт хорооны бөх, аймгийн начин Б.Мөнхбаяр үзүүрлэж “Аймгийн заан” цол, үндэсний сурын харваанд Улаанбаатар, Төв, Завхан аймаг, Эрдэнэбулган, Жаргалант, Чулуут сумдын 50 гаруй харваач цэц мэргэнээ сорьсноос эрэгтэй төрөлд, Эрдэнэбулган сумын харьяат “ЭБЦТС” ТӨХК-ний харваач Д.Мягмарсүрэн түрүүлж “Аймгийн мэргэн”, эмэгтэй төрөлд Төв аймгийн Борнуур сумын уугуул, “Төв цэц мэргэн” багийн харваач, спортын мастер Д.Бадамхорлоо түрүүлж “Аймгийн мэргэн” цолыг тус тус хүртсэн байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийг Эрдэнэбулган сумын 4 байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төслийн бэлтгэл үе шатны хүрээнд тухайн 4 байршилд төлөвлөлтийн зураг төслийн эхний хувилбарыг боловсруулж, орон сууц өмчлөгч, эзэмшигчдийн төлөөллүүдтэй 7-р сарын 8-ны өдөр аймгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагын хүмүүс уулзаж, төслийн төлөвлөгөөнд санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр уулзалтад ирсэн иргэдийн ихэнх нь дахин төлөвлөлтийн ажлыг дэмжсэн байна.

Тарваган тахал, COVID-19 коронавируст халдварын өнөөгийн эрсдэлтэй нөхцөл байдалтай холбогдуулан ЗӨСҮТ-ийн ерөнхий захирал, доктор Н.Цогбадрах тарваган тахлын өндөр эрсдэлтэй аймгуудын нэг Архангай аймагт 7-р сарын 22-ны өдөр ажиллан аймгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийж тарваган тахал өвчний өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийн, орон нутгийн засаг захиргаа, хууль хяналтын байгууллага, салбар дундын байгууллагуудын хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг анхааруулж, тарваган тахал өвчний байгалийн голомттой нутаг дэвсгэрт сэрэмжлүүлэг самбар байрлуулах, эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, эмнэлгийн эмч ажилтнуудыг тарваган тахал өвчний

халдварт өртөхөөс сэргийлэх, иргэдийн өөрсдийгөө болон гэр бүл, эмнэлгийн эмч ажилтнуудын халдварт өртөхөөс сэргийлэх дадал хандлагыг өөрчлөх, хууль бус тарвага агналтанд хяналт тавих, төв суурин газарт халдвар тарахаас сэргийлэх чиглэлээр суурин болон хөдөлгөөнт эргүүл постуудыг ажиллуулж, хууль хяналтын байгууллагын хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллахыг үүрэг болголоо.

Ойг хамгаалах, зүй зохистой ашиглуулах зорилгоор самрын болц гүйцэхээс нь өмнө түүж бэлтгэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд хушин ой бүхий сумдын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүдийн 60 гаруй төлөөллийг хамруулсан уулзалтыг 7-р сарын 28-ны өдөр зохион байгуулсан.

Мөн энэ үеэр ойн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор хуш модны самрыг 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө түүж бэлтгэхийг хориглосон аймгийн Засаг даргын 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн А/502 дугаар захирамж гарсан бөгөөд дээрхи хугацаанаас өмнө самар түүж бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг торгож, багаж, тоног төхөөрөмж, техникийг хураах хүртэлх арга хэмжээ авахаар заасан байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

7-р сард улсын төсөвт 398700.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 3965279.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс, улсын төсөвт 401200.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 4165070.1 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Цахим төлбөрийн баримтын систем ашиглан татвараа төлөх талаар Архангай аймгийн Татварын хэлтсийн цахим хуудсанд мэдээ, мэдээллийг байршуулан 41 татвар төлөгчийн бүртгэлтэй хаягаар илгээлээ.

Төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор угтах үйлчилгээнээс 219 татвар төлөгчид татварын бүх төрлийн үйлчилгээг нэг доороос чирэгдэлгүй хүргэсэн байна.

Шинэчлэгдсэн батлагдсан хууль, тайлангийн маягтын өөрчлөлтийг татвар төлөгчдөд цахим сайтаар хүргэн, угтах үйлчилгээнээс цахим тайлангийн системд нэвтрэх талаар арга зүйн зөвлөгөөг 36 татвар төлөгчид өгч, тайлангийн ирцийг 94.5 хувьтай хангуулсан байна.

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49.076.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 7-р сарын байдлаар 8.202.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Үүнээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 18.5 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 406.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 132.7 сая төгрөгийн 3, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчит 26 төсөвт байгууллагад 48.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгож, 3 төсөвт байгууллагад 22.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд бүртгэх зөвшөөрлийг олгож, 12 төсөвт байгууллагад 358 нэр төрлийн 291.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл олгосон.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1982.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээний тендерийг зарласан.

Санхүүгийн хяналт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд, аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан гэрээнд тусгагдсаны дагуу аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын 2018-2019 оны үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалт хийж, нийт 9 төрлийн актаар 14.1 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, төсвийн орлогод хураан барагдуулах, нөхөн олгуулахаар шийдвэрлэж, зөрчлийг арилгуулах, төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж чиглэл өгч, дүнг холбогдох саналуудын хамт ХХААХҮЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн.

7-р сарын байдлаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны 2019 оны жилийн эцсийн дүн болон тогтоосон нөхөн төлбөрийн барагдуулалтад дотоод аудит хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

7-р сард 8 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдсоноос объектын гал түймэр 3, мал, амьтны гоц халдварт өвчин 2, хүчтэй шороон шуурга 1, үерийн дуудлага 1, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1 тус тус тохиолдож, өвөл зуны сууц 3, автомашин 5, мотоцикль 1 шатаж, 3 хүн амь насаа алдаж, 14 хүн түлэгдсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байрлалтай Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт шалгалтыг 2020 оны 6-р сарын 15-ны өдрөөс 7-р сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, 12 объект хамрагдаж, гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 94 зөрчил илрүүлж, 25 зөрчлийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 5, танилцуулга 1-ийг тус тус байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Шадар сайдын баталсан “Үер усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд аймгийн хэмжээнд үер усны ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор 16 заалт бүхий төлөвлөгөөг хэрэгжүүлж, амрагч, аялагчид олноор цуглардаг хойд болон урд Тамирын голын дагуу завьт болон явган эргүүлийг зохион байгуулж, нийт 300 гаруй иргэн, голын эрэг дагуу буусан 35 айл өрхөд 250 ширхэг үер, усны ослоос урьдчилан сэргийлэх санамж гарын авлага тарааж, заавар зөвлөгөө өгсөн.

Өгийнуур, Тэрхийн цагаан нууранд аялал, зугаалгаар амарч байгаа иргэдийн хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар хамтран үер, усны ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой байдлын газрын даргын 2020 оны 7-р сарын 17-ны өдрийн А/63 дугаар тушаалаар баталсан удирдамж, чиглэлийн дагуу 7-р сарын 17-ны өдрөөс 20-ны өдрүүдэд Өгийнуур, Тэрхийн цагаан нууранд завьт эргүүлийн үүрэг гүйцэтгэж 1000 гаруй иргэнд анхааруулга өгч, үер усны ослоос урьдчилан сэргийлэх 600 санамж гарын авлагыг тарааж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.

2020 оны 6-р сард аймгийн хэмжээнд 255 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 57, хулгайлах гэмт хэрэг 130, малын хулгайн гэмт хэрэг 70, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 11, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 43, гэмт хэргийн илрүүлэлт 37.4 хувьтай байна.

Нийт 12828 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 12378 иргэнд 349 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1026.5 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 34.8 хувьтай байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 7-р сард 2643607.5 төгрөгийн мөнгөн дүн бүхий 455 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 40.4, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 30.8 байна.

Шүүхийн шинжилгээний алба 7-р сард криминалистикийн шинжилгээ 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 82, шүүх эмнэлгийн шинжилгээ 99, тусгай шинжилгээ 21-г тус тус хийсэн байна.

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр жижиглэн худалдаа эрхлэгч 7, хоол үйлдвэрлэл, зочид буудал, жуулчны бааз эрхлэгч 4, нийт 11 иргэн аж ахуй нэгжийн үйлчилгээнд, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын чиглэлээр масс хэмжих хэрэгсэл 6, цахилгаан хэмжих хэрэгсэл 10, нийт 16 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийж тохирлын гэрчилгээ олгосон байна.

Иргэний бүртгэл

2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагаа нь 2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагааг ажлаар өөрсөдөө бусад ажиллагаагаар үргэлжлүүлж байна.

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 133

Гэрлэлтийн бүртгэл - 16

Гэрлэлт цуцалсаны бүртгэл – 0

Эцэг тогтоосны бүртгэл - 3

Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 3

Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 12

Нас баралтын бүртгэл - 39

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 135

Дахин олгосон – 91

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 296 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэл

2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагаа нь 2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагааг ажлаар өөрсөдөө бусад ажиллагаагаар үргэлжлүүлж байна.

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 27

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 11

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 2

Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 85

Арилжааны гэрээ – 0

Худалдах худалдан авах гэрээ – 53

Бэлэглэлийн гэрээ – 19

Барьцааны эрхийн бүртгэл – 170

Өв залгамжлал – 3

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 5

Лавлагаа – 0

Бусад эрхийн бүртгэл – 8

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагаа нь 2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагааг ажлаар өөрсөдөө бусад ажиллагаагаар үргэлжлүүлж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагаа нь 2020 ойн 7-р сарын 27-ны өдрийн мөрдөгч ажиллагааг ажлаар өөрсөдөө бусад ажиллагаагаар үргэлжлүүлж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2020 оны 7-р сарын 02-ноос 05-ны өдрүүдэд Эрдэнэбулган сумын 1, 2, 4-р сургуулиуд дээр 1 ангид 10 хүүхэд байхаар тооцож боловсролын үнэлгээний төвийн 7 хүний бүрэлдэхүүнтэй баг, 44 зохион байгуулагч багш, 56 хянагч багш, 18 үйлчлэгч, 3 эмч, Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын хэлтсийн албан хаагч нар хамтран зохион байгууллаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд 974 элсэгч бүртгүүлж, давхардсан тоогоор 2927 шалгуулагчийн материалыг шууд засалтын програмаар засаж аймгийн Боловсрол, соёл,

урлагийн газрын раге хуудсаар шууд дамжуулсан бөгөөд шалгалт тус бүр дээр ирц 92-100 хувьтай байв.

Аймгийн Засаг даргын 2018 оны 5-р сарын 16-ны өдрийн А/221 дүгээр захирамжаар баталсан журмын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 6 сурагч, 750 оноо авсан 19 сурагч, тэднийг бэлтгэсэн багш нарыг 7-р сарын 10-ны өдрийн баярын хурал дээр шагнаж урамшууллаа.

БСШУСЯ-наас 1-5 ангийн сурагчдын нөхөн хангалтын сургах бичгийн 45 хувийг хүлээн авч хуваарилах ажлыг зохион байгуулж байна.

Соёл, урлаг

Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 35 уншигч бүртгэж, 119 ирэгсдэд 486 ширхэг ном хэвлэлээр, тогтмол хэвлэлийн фондоос 25 ирэгсдэд сонин хэвлэлээр тус тус үйлчилж, 3374 номыг электрон каталогит оруулсан байна.

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газар, Математик тоон технологийн хүрээлэн, аймгийн Музей, Ихтамир сумын Соёлын төв хамтран хадгалалт хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлах зорилгоор 7-р сарын 23-ны өдөр Тайхар чулууны гадаргуу хэсгийн механик бохирдол болох будаг, сүү, тосны бохирдол хими биологийн гэмтлээс хамааралтай чулуулгийн өгөршил, өнгөний гандалт, хүрээлэн буй орчны анхан шатны эрсдэлийг тодорхойлж эдгээр гэмтэл бохирдлыг цэвэрлэх, бэхжүүлэх арга зүйг боловсруулж тус дурсгалын онцлогт тохируулан хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах анхан шатны сорьц судалгаа хийсэн байна.

Хөгжимт драмын театр Ардын хувьсгалын 99 жил, аймаг байгуулагдсаны 97 жилийн түүхт ойн баяр наадамд зориулан “АВ” телевизтэй хамтран телевизийн контент нэвтрүүлгийг бэлтгэн баяр наадмын өдрүүдэд үзэгчдийн хүртээл болголоо.

Эрүүл мэнд

2020 оны эхний 6 сарын байдлаар нийт ор хоног 74285, ор хоногийн гүйцэтгэл 98.2 хувь, дундаж ор хоног 7.0, нийт үзлэг 178050, гүйцэтгэлийн хувь 81.7 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгийн гүйцэтгэл өссөн дүнгээр 63493, гүйцэтгэлийн хувь 35.7 байна.

Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл 46572, өмнөх оны энэ үеэс 4912 тохиолдлоор нэмэгдсэн, бүртгэгдсэн халдварт бус өвчлөлийн 19048 буюу 40.9 хувь нь шинэ өвчлөл буюу анх удаа оношлогдсон өвчин байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл нийт 905 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны энэ үеэс 1.6 дахин өссөн байна.

Нийт бүртгэгдсэн халдварт өвчин 180, өмнөх оны энэ үеэс 111 тохиолдлоор буурсан байна. Үүнээс цочмог халдварт өвчин 82 тохиолдол өмнөх оны энэ үеэс 32 тохиолдлоор буурсан, архаг халдварт өвчин 98 тохиолдол өмнөх оны энэ үеэс 79 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 681 төрөлт бүртгэгдсэн бөгөөд ихэр төрсөн эхийн тоо 12, амьд төрсөн хүүхэд 834, амьгүй төрсөн 5 хүүхэд, өмнөх оны энэ үеэс төрөлт 19 тохиолдлоор өссөн, амьгүй төрөлт 3 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Нийт нас баралт 231 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны энэ үеэс 37 тохиолдлоор буурсан, эмнэлгийн нас баралтын 42 тохиолдол гарсан бөгөөд үүнээс 33,3 хувь нь хоног болоогүй нас баралт, гэрийн нас баралт 189, нийт нас баралтын 81.8 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн нас баралт 49 тохиолдол гарсан бөгөөд өмнөх оны энэ үеэс 12 тохиолдлоор буюу 1.3 дахин өссөн, нийт нас баралтын 21.2 хувийг эзэлж байна.

Нялхсын эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.4 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 2.9-өөр буурсан үзүүлэлттэй байна.

0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 20.4 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 1.8-аар буурсан байна.

“Ковид 19” вирусын халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ өглөө бүр 07-09 цагийн хооронд нийтдээ 24 эрүүл мэндийн байгууллагуудаас хүлээн авч, нэгтгэн ЭМХҮТ болон ЭМГ-ын удирдлагуудад цахимаар хүргүүлэн, ажиллаж байна.

ДЭМБ-ын санхүүжилтээр 19 сумын Эрүүл мэндийн төвийн нийт 460 эмч, эмнэлгийн ажилчдад “Коронавируст халдварын үеийн удирдлага, зохион байгуулалт, халдварын сэргийлэлт хяналт, эмнэлзүйн менежмент” сургалт зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлж, 19 суманд бэлэн байдлын үнэлгээ хийж, заавар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн.

Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.2.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.3.5, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8.6 дахь заалтыг тус тус үндэслэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийн мөрөөр мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилж буй эм хангах нийлүүлэх байгууллага, сумдын эмийн сан болон нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудаас албан хүсэлт авч тусгай зөвшөөрөл олгох комисст асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн.

Мөн Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/68 дугаар тушаалаар баталсан журмын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сум дундын болон сумын Эрүүл мэндийн төв, өрхийн Эрүүл мэндийн төв, сумдын эмийн сан, Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 1-р зэрэглэлийн эмийн сангуудын 2019-2020 онд хэрэглэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлага, зарцуулалтын тайлан, эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт (MNS 5376:2014) дагуу жорын маягтын зарцуулалтын тайланг гаргуулж аймгийн Цагдаагийн газарт хүргүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 7-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 980 иргэн бүртгэлтэй байгаагаас 504 эмэгтэй. Шинэ ажлын байр 438, үүнээс байнгын ажлын байр 219, улирлын ажлын байр 25, түр ажлын байр 194 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 414, зуучлал 396 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 99 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал, боловсролгүй-6, бага- 24, суурь-247, бүрэн дунд- 530, техникийн болон мэргэжлийн анхан шатны-16, тусгай мэргэжлийн дунд-17, Дипломын бакалаврын-140 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 11 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХ-т хүргүүлсэн.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээний хүрээнд 18 сумын 19 иргэн хамрагдаж 76.0 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг олгож, байнгын ажлын байраар хангасан.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд Батцэнгэл сумын ажил хайгч 18 иргэнийг хамруулж 4480.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож өрхийн орлогыг нэмэгдүүллээ.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 7-р сарын 25-ны байдлаар нийт 10.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 118 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 15.5 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 31.2 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 3597.0 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 7-р сарын байдлаар 10.3 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 тэрбум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

Тэтгэврийн даатгалын санд 65 % буюу 6712.4 сая төгрөг

Тэтгэмжийн даатгалын санд 7.3 % буюу 757.9 сая төгрөг;

ҮОМШӨ-ний даатгалын санд 5.5 % буюу 568.9 сая төгрөг;

Ажилгүйдлийн даатгалын санд 1.7 % буюу 171.1 сая төгрөг;

Эрүүл мэндийн даатгалын санд 20.5% буюу 2081.7 сая төгрөг
2020 оны 7-р сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 33.7 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 5.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

“Хүүхдүүдээ гэнэтийн ослоос урьдчилан сэргийлье” аяны хүрээнд Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн 15 байгууллага, 9 аж ахуйн нэгж, 4 сургууль, 10 цэцэрлэг “Хүүхдийн орчны эрсдлийн үнэлгээ”-г хийж хамтран ажилласан.

Нийт байгууллага, аж ахуйн нэгжийн 97.3 хувь нь эрсдлээ урьдчилан харж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд эрсдэлгүй, ээлтэй орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Германы хөгжлийн агентлаг, үндэсний тогтвортой хөгжил хоорондын хамтын ажиллагааны “Нэмүү өртгийн сүлжээг дэмжих” төсөлтэй хамтран “Хонь хяргах, угаах загвар төв”-ийн үзүүлэх сургалтыг 6-р сарын 29, 30-ны өдрүүдэд Хотонт, Өлзийт суманд бүсчлэн зохион байгуулж, Хотонт, Хашаат, Өгийнуур, Өлзийт, Хайрхан, Батцэнгэл сумын хөдөө аж ахуйн тасгийн мал аж ахуйн мэргэжилтнүүд, малчдын төлөөлөл, нийт 80 гаруй хүн оролцсон байна.

Нян судлалын шинжилгээг давхардсан тоогоор 8 сумын 10 эмгэгт дээж буюу 37 эмгэгт материалд заавар арга зүйн дагуу хийхэд дотрын халдварт хордлого-2, цусан халдварт-2, галзуу-3, нийт 7 халдварт өвчин тодорхойлогдож дээрх өвчнүүдтэй тэмцэх зааврын дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Газар тариалан

Архангай аймаг 2020 онд үр тариа 10000 га-д, тэжээлийн таримал 1150 га-д, тосны таримал 1500 га-д, төмс 264 га-д, хүнсний ногоо 139 га-д нийт 13222 га талбайд тариалахаас үр тариа 7849 га-д, тосны ургамал 901 га-д, малын тэжээл 3000 га-д, төмс 264 га-д, хүнсний ногоо 140 га-д, жимс жимсгэнэ 150 га талбайд тус тус тариалж аймгийн хэмжээнд нийт 12304 га талбайд тариалалт хийсэн бөгөөд энэ жилийн төлөвлөгөөт тариалалтыг 93 хувьтай хийж гүйцэтгэлээ.

Хүнс хөдөө аж ахуйн газраас хуваарилсан 3 сая төгрөгийн өртөг бүхий 94 кг үрийг 19 сумын 188 иргэн, аж ахуй нэгжид, НҮБ-аас олгосон 71 кг 2.3 сая төгрөгийн өртөг бүхий 71 кг үрийг Эрдэнэбулган сумын газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 18 иргэн, аж ахуй нэгжид олгосон.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлал

Нийслэлийн аялал жуулчлалын газраас санаачлан хэрэгжүүлж буй “Хоггүй аялал гоё” аянд 7-р сарын 2-ны өдөр Архангай аймаг албан ёсоор нэгдэж, сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт зөвлөмж хүргүүлж, 7-р сард Эрдэнэбулган, Ихтамир, Өгийнуур, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Цахир сумдад аян өрнүүлж, давхардсан тоогоор 10.000 орчим гарын авлага, хогийн уут тарааж, цахим орчинд 100.000 орчим хүнд мэдээлэл хүргэлээ.

“Хандлагаа өөрчилъё”, “Цэвэрхэн наадацгаая” уриалгын хүрээнд аймгийн баяр наадмын үеэр иргэдэд халуун хоол цайгаар үйлчилж, 100 гэрт хог хаягдлын уут тараасан.

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

Орон нутгийн мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, өндөг, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл, сум, орон нутгаасаа сургуулийн хоол үйлдвэрлэлд нийлүүлж байгаа хүнсний түүхий эд,

бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, хангамжийн түвшний судалгаа болон “Захиргааны статситик мэдээллийн үзүүлэлт, заавар батлах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн 2020 оны 4-р сарын 29-ний өдрийн А/138 дугаар тушаалын дагуу махны агуулах, зоорины судалгааг тус тус гаргаж ХХААХҮЯ-д хүргүүлсэн.

Хүнсний нөөцийн сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 1 тн буюу 1 хоног, гурил 234 тн буюу 31 хоног, гоймон 27.7 тн буюу 2 хоног, будаа 89.9 тн буюу 24 хоног, сахар 59.5 тн буюу 24 хоног, ургамлын тос 23.9 тн буюу 13 хоног, давс 21.2 тн буюу 53 хоног, ундны ус 48.5 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 4.3 тн буюу 3 хоног, төмс 28.7 тн буюу 11 хоног, хүнсний ногоо 15.3 тн буюу 1 хоног, өндөг 0.85 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Барилга, дэд бүтэц

Архангай аймагт 2020 îîä уёñüí ò°ñвийн 79.378,9 сая төгрөгийн хөрөнгөөр 41 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжийн сангийн 955.0 сая төгрөгийн хөрөнгөөр 8 төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 1.703,6 сая төгрөгийн өртөг бүхий 22 төсөл арга хэмжээ, нийт 82 тэрбум 37.5 сая төгрөгийн өртөг бүхий 71 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээд ажиллаж байна.

7-р сард Хотон сумын Бургалдай багийн төв, Булган сумын Тамир багийн төв, Эрдэнэбулган сумын 4-р багийн цэцэрлэгийн засвар, Хангай сумын Тэрх багийн төвийн барилга гэсэн 4 барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авсан. Эрдэнэбулган сумын механикжсан зоорийн ажлын гэрээ хийгдэж ажлыг эхлүүлсэн, Чулуут, Жаргалант, Булган сумдын 240 хүний суудалтай 3 Соёлын төвийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгосон.

-----oOo-----